



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/1145

Улаанбаатар хот

**Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл,
тусгай үүргийн бэлтгэл шатны сургалтыг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "а", 29.2 дахь хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Тэргүүлэгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 18 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1109 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн дүйцүүлэх албаны цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад 2020 оны 05 дугаар сард элсэн үүрэг гүйцэтгэж буй 8 иргэн, Сургалтын төвийн салаан захирагчаар томилогдсон Цэргийн штабын шуурхай байдлын ахлагч П.Магнайбаяраар ахлуулан 2020 оны 09 дүгээр сарын 18-наас 27-ны өдрүүдэд хамруулахыг Цэргийн штаб /хурандаа Б.Батмөнх/-т үүрэг болгосугай.

2. Сургалтад хамрагдах бэлтгэл үүрэгтнүүдийн нэрийн жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, хоол, унааны төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, сургалтын зардал болох 1.096.200 /Нэг сая ерэн зургаан мянга хоёр зуун/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч /С.Баасанхүү/-д зөвшөөрсүгэй.

3. Цэргийн дүйцүүлэх албаны анхан болон тусгай үүргийн бэлтгэл сургалтад бие бүрэлдэхүүнийг бүрэн хамруулан, осол, зөрчилгүй зохион байгуулж, тайлан, мэдээг журамд заасан хугацаанд нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүргүүлэх, санхүү бүртгэлийн тайлан тооцоог бүрдүүлэн ирүүлэх, сургалтын талаар 2020 оны 09 дүгээр сарын 30-нд тайлагнахыг Цэргийн штаб /хурандаа Б.Батмөнх/-т даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар /Л.Санжийжамц/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА **С. Эрдэнэбаяр** С.ЭРДЭНЭБАЯР



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2020 оны 09 сарын 15-ны өдрийн 2/145 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБЫГ БИЕЭР ХААГЧДИЙН
ТУСГАЙ ҮҮРГИЙН БЭЛТГЭЛ ШАТЫН СУРГАЛТАД ХАМРАГДАХ
БҮРЭЛДЭХҮҮНИЙ НЭРИЙН ЖАГСААЛТ

Д/д	Овог нэр	Регистр	Албан тушаал	Элссэн он	Тайлбар
1	Пүрэвдагва Магнайбаяр	ПЮ77092213	Салааны захирагч	2020	
2	Очирбат Мөнхбадрах	МР97112819	Дүйцүүлэх алба хаагч	2020	
3	Содовжамц Хосбаяр	НЦ97102412	Дүйцүүлэх алба хаагч	2020	
4	Хишигдолгор Бямбатулга	НЦ98112113	Дүйцүүлэх алба хаагч	2020	
5	Гантулга Өлзийбат	НЦ00321110	Дүйцүүлэх алба хаагч	2020	
6	Нямхишиг Өлзийтогтох	НЦ00260816	Дүйцүүлэх алба хаагч	2020	
7	Насанбат Нямбазар	АИ99022810	Дүйцүүлэх алба хаагч	2020	
8	Төмөрбаатар Баярбаатар	НЦ00310311	Дүйцүүлэх алба хаагч	2020	
9	Цогбадрах Алтай	УП98053116	Дүйцүүлэх алба хаагч	2020	